



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/179/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: У.Батчимэг Утас: 70432545 Цахим хаяг: batchimegu@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Төлбөрийн акт	11
3.2 Зөвлөмж	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	15
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	16
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

- Байгууллагын түүхт 100 жилийн ойн хандивын тооцоо бодоогүй, хувийн харилцах дансанд төвлөрүүлэн байгууллагын дансанд тушаасан байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсад хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулан байгууллагын нэмэлт дансаар 53.1 сая төгрөгийн мөнгөн орлого бүрдүүлж, зарцуулсан байна.

Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/178 дугаар тушаалаар 76.1 сая төгрөгийг машин тоног төхөөрөмж, худалдан худалдан авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 149.9 сая, Хүүхэд гэр бүл, хөгжил хамгааллын газраас 110.4 мянга, дугуйлангийн орлого, түрээс, зуслангийн орлого, хандивын орлогоор 75.2 мянга, нийт 335.3 мянган төгрөгийг орлогыг зарцуулж, оны эцэст 1.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж тогтвортой байдлыг хангах замаар хүүхдийн эрх, хамгаалал, хөгжил, оролцоог төрийн бодлого, хуулийн хүрээнд хэрэгжүүлж аз жаргалтай, ирээдүйд итгэлтэй хүүхэд өсвөр үеийг төлөвшүүлэхэд оршино эрхэм зорилгын хүрээнд 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 48 арга хэмжээг батлан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>87,670,012.03</u>	<u>100,035,056.03</u>
33	АВЛАГА	4,472,970.03	4,472,970.03
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,472,970.03	4,472,970.03
35	БАРАА МАТЕРИАЛ	83,197,042.00	95,562,086.00
354	Хангамжийн материал	83,197,042.00	95,562,086.00
35420	Аж ахуйн материал	83,197,042.00	94,413,036.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,149,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,861,717,020.20</u>	<u>2,857,754,932.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,861,717,020.20	2,857,754,932.66
392	Биет хөрөнгө	2,779,902,582.56	2,776,163,995.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,712,522,404.00	2,712,522,404.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,168,255.30)	(191,154,479.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(13,708,333.14)	(16,058,333.10)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	146,604,325.00	231,679,725.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(87,520,474.38)	(113,997,004.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,841,553.00	65,051,353.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,162,020.30)	(41,123,053.74)
39214	Бусад үндсэн хөрөнгө	178,367,170.00	178,367,170.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(81,139,786.32)	(87,389,786.28)
39217	Ном	14,766,000.00	14,766,000.00
393	Биет бус хөрөнгө	81,814,437.64	81,590,937.64
39301	Програм хангамж	7,093,000.00	7,093,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,183,162.36)	(6,406,662.36)
39303	Бусад биет бус хөрөнгө	80,904,600.00	80,904,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,949,387,032.23</u>	<u>2,957,789,988.69</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,949,387,032.23</u>	<u>2,957,789,988.69</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,949,387,032.23	2,957,789,988.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,301,682,672.00	1,301,682,672.00
51101	Өмч: - төрийн	1,301,682,672.00	1,301,682,672.00
512	Хуримтлагдсан үр дүн	849,582,669.38	857,985,625.84
51210	Өмнөх үеийн үр дүн	849,582,669.38	849,582,669.38
51220	Тайлант үеийн үр дүн	-	8,402,956.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	798,121,690.85	798,121,690.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,949,387,032.23</u>	<u>2,957,789,988.69</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<u>2,651,708,901.64</u>	<u>3,357,017,068.36</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>904,811,593.64</u>	<u>187,123,568.36</u>
120	Нийтлэг татварын бус орлого	904,811,593.64	133,212,568.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	904,811,593.64	133,212,568.36

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,651,555.64	15,999,788.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	11,827,200.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		15,390,380.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	884,160,038.00	89,995,200.00
122	Тусламжийн орлого	-	53,911,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	53,911,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,746,897,308.00	3,169,893,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,510,904,600.00	2,909,879,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,510,904,600.00	2,909,879,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,992,708.00	260,013,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,709,000.00	149,993,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,283,708.00	110,020,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,786,000,413.07	3,348,614,111.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,786,000,413.07	3,348,614,111.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,666,890,492.72	3,228,259,760.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	824,593,337.26	1,689,889,377.23
210101	Үндсэн цалин	597,589,769.26	795,601,048.22
210102	Нэмэгдэл	227,003,568.00	571,248,683.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	244,079,145.70
210104	Урамшуулал	-	78,960,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,662,875.57	230,130,978.00
210201	Тэтгэврийн даатгал	70,947,574.92	158,222,878.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,245,933.32	17,977,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,767,831.94	8,988,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,609,230.49	8,988,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,092,304.90	35,954,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	184,541,802.07	322,727,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,338,602.07	11,411,697.00
210302	Түлш, халаалт	169,539,800.00	300,043,400.00
210303	Цэвэр, бохир ус	9,663,400.00	11,272,803.00
2104	Хангамж, бараа материалын зардал	208,394,430.00	60,054,763.58
210401	Бичиг хэрэг	1,308,520.00	7,558,833.03
210402	Тээвэр, шатахуун	3,072,600.00	9,746,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	327,900.00	3,295,444.55
210404	Ном, хэвлэл	-	3,748,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	253,920.00	4,292,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	203,431,490.00	31,413,586.00
2105	Нормативт зардал	-	73,918,540.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,112,410.00
210502	Хоол, хүнс	-	54,127,530.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	16,678,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,480.00	19,629,406.00
210604	Урсгал засвар	9,480.00	19,629,406.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	33,859,400.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	33,859,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	281,936,358.22	545,811,874.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	281,194,958.22	542,698,874.36
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,700.00	16,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	202,000.00	1,048,000.00
210807	Газрын төлбөр	244,500.00	1,148,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,626,209.60	252,237,521.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,695,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	152,295,134.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,626,209.60	98,247,287.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,109,920.35	120,354,351.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,771,366.83	11,863,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	11,863,210.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,338,553.52	108,491,141.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,338,553.52	108,491,141.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>865,708,488.57</u>	<u>8,402,956.46</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>865,708,488.57</u>	<u>8,402,956.46</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672	798,270,586.09	(13,895,241.55)	2,086,058,016.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,230,577.64)	(2,230,577.64)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672	798,270,586.09	(16,125,819.19)	2,083,827,438.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(148,895.24)	-	(148,895.24)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	865,708,488.57	865,708,488.57
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672	798,121,690.85	849,582,669.38	2,949,387,032.23
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,301,682,672	798,121,690.85	849,582,669.38	2,949,387,032.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,301,682,672	798,121,690.85	849,582,669.38	2,949,387,032.23
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	8,402,956.46	8,402,956.46
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,301,682,672	798,121,690.85	857,985,625.84	2,957,789,988.69

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,767,548,863.64</u>	<u>3,251,631,488.36</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,651,555.64	81,737,988.36
120	Нийтлэг татварын бус орлого	20,651,555.64	27,826,988.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,651,555.64	27,826,988.36
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,651,555.64	15,999,788.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	11,827,200.00
122	Тусламжийн орлого	-	53,911,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	53,911,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,746,897,308.00	3,169,893,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,510,904,600.00	2,909,879,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,510,904,600.00	2,909,879,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	235,992,708.00	260,013,800.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	126,709,000.00	149,993,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,283,708.00	110,020,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,767,548,863.64</u>	<u>3,247,341,488.36</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,767,548,863.64	3,247,341,488.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,647,567,443.29	3,116,386,437.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	828,912,100.00	1,689,089,377.23
210101	Үндсэн цалин	415,034,204.49	795,601,048.22
210102	Нэмэгдэл	274,877,299.00	570,448,683.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	90,025,096.51	244,079,145.70
210104	Урамшуулал	48,975,500.00	78,960,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,614,100.00	230,130,978.00
210201	Тэтгэврийн даатгал	70,457,500.00	158,222,878.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,289,200.00	17,977,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,144,600.00	8,988,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,144,600.00	8,988,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,578,200.00	35,954,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	184,899,779.65	322,727,900.00
210301	Гэрэл, цахилгаан	5,696,579.65	11,411,697.00
210302	Түлш, халаалт	169,539,800.00	300,043,400.00
210303	Цэвэр, бохир ус	9,663,400.00	11,272,803.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,757,200.00	30,968,869.58
210401	Бичиг хэрэг	2,471,500.00	7,046,300.00
210402	Тээвэр, шатахуун	590,500.00	14,199,100.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	327,900.00	3,230,577.58
210404	Ном, хэвлэл	-	4,448,892.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	367,300.00	2,044,000.00
2105	Нормативт зардал	-	79,385,174.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	3,287,160.00
210502	Хоол, хүнс	-	55,285,930.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	20,812,084.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,030,600.00	19,726,806.00
210604	Урсгал засвар	30,600.00	19,726,806.00
2107	Томилолт, зочны зардал	126,000.00	31,860,050.00
210702	Дотоод албан томилолт	126,000.00	31,860,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	501,491,663.64	525,939,088.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,750,263.64	523,366,088.36
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	26,700.00	16,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	202,000.00	508,000.00
210807	Газрын төлбөр	244,500.00	1,148,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,736,000.00	186,558,194.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,568,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,736,000.00	183,990,094.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,981,420.35	130,955,051.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,642,866.83	22,463,910.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,471,500.00	22,463,910.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,338,553.52	108,491,141.19
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,338,553.52	108,491,141.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	<u>4,290,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	4,290,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	4,290,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	4,290,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,290,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	<u>-4,290,000.00</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,010,914,100.00	2,807,948,558.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,010,914,100.00	2,807,948,558.81

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,949,532,000.00	2,785,484,648.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,785,344,300.00	1,645,746,755.23
210101	Үндсэн цалин	889,380,000.00	779,162,356.99
210102	Нэмэгдэл	510,834,400.00	543,544,752.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	218,628,500.00	244,079,145.70
210104	Урамшуулал	166,501,400.00	78,960,500
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	224,713,200.00	224,713,200
210201	Тэтгэврийн даатгал	152,805,100.00	152,805,100
210202	Тэтгэмжийн даатгал	17,977,000.00	17,977,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,988,500.00	8,988,500
210204	Ажилгүйдлийн даатгал	8,988,500.00	8,988,500
210205	Эрүүл мэндийн даатгал	35,954,100.00	35,954,100
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	322,727,900.00	322,727,900
210301	Гэрэл, цахилгаан	11,767,200.00	11,411,697
210302	Түлш, халаалт	300,043,400.00	300,043,400
210303	Цэвэр, бохир ус	10,917,300.00	11,272,803
2104	Хангамж, бараа материалын зардал	35,253,000.00	30,796,870
210401	Бичиг хэрэг	7,082,000.00	6,874,300
210402	Тээвэр, шатахуун	14,744,800.00	14,199,100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,960,200.00	3,230,578
210404	Ном, хэвлэл	4,448,900.00	4,448,892
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,017,100.00	2,044,000
2105	Нормативт зардал	76,056,400.00	64,825,174
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,465,800.00	3,287,160
210502	Хоол, хүнс	48,322,500.00	41,035,930
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,268,100.00	20,502,084
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,450,000.00	9,450,000
210604	Урсгал засвар	9,450,000.00	9,450,000
2107	Томилолт, зочны зардал	29,388,900.00	26,884,050
210702	Дотоод албан томилолт	29,388,900.00	26,884,050
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	410,440,500.00	404,182,900
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	402,431,200.00	401,609,900
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	900,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	313,600.00	16,200
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,034,300.00	508,000
210807	Газрын төлбөр	1,148,800.00	1,148,800
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,157,800.00	56,157,800
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,568,100.00	2,568,100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,589,700.00	53,589,700
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,382,100.00	22,463,910
2132	Бусад урсгал шилжүүлэг	61,382,100.00	22,463,910
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,733,100.00	22,463,910
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,010,914,100.00	2,807,948,558.81
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,005,914,100.00	2,802,948,558.81

131001	Улсын төсвөөс санхүүжих	3,005,914,100.00	2,802,948,558.81
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,000,000.00	5,000,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000
	мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	335,191,788.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	335,191,788.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,191,788.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	43,342,622.00
210101	Үндсэн цалин	18,703,866.18
210102	Нэмэгдэл	24,638,755.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,417,778.00
210201	Тэтгэврийн даатгал	5,417,778.00
2104	Хангамж, бараа материалын зардал	172,000.00
210401	Бичиг хэрэг	172,000.00
2105	Нормативт зардал	14,560,000.00
210502	Хоол, хүнс	14,250,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	310,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,276,806.00
210604	Урсгал засвар	10,276,806.00
2107	Томилолт, зочны зардал	4,976,000.00
210702	Дотоод албан томилолт	4,976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,046,188.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,046,188.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130,400,394.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,400,394.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	335,191,788.36
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	335,191,788.36
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,993,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	110,020,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,177,988.36

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 303,043.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 154,239.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Цалингийн зардал 4,202.0 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Үнэ төлбөргүйгээр хүлээн авсан үндсэн хөрөнгө болон бараа материалын 25,992.1 мянган төгрөгийн дүнг бүртгэлд дутуу тусгасан;
- Хандивын орлого болон дугуйлангийн орлогыг 3,637.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Тайлант үеийн үр дүнгийн зардал 9,186.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэг шилжүүлэг 106,931.1 мянган төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэн;
- Биет ба биет бус хөрөнгө худалдан авсны зардал 4,290.0 мянган төгрөгийг бүртгээгүй

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 148,804.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 135,445.5 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрснээс, 3,073.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 8 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

5.1.1 Хүүхэд, Гэр бүлийн, Хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/64 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 3,073.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон .

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдад олгосон илүү цагийн хөлсний бүртгэл бүрэн бус, ээлжийн ажилтай жижүүр багш нарын цагийн тооцоог нарийвчлан бүртгээгүй, зарим албан хаагчдын илүү цагийг Хөдөлмөрийн хуульд заасны дагуу олгоогүй, цагийн тооцооны баталгаажсан хүснэгтэд заасны дагуу цалин хөлс олгохгүй байгаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", МУЗГ-ын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын гурав "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна, 4.1. улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах;" гэж заасан заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдад олгох илүү цагийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллаж, хууль тогтоомжид заасны дагуу илүү цагийн хөлсийг олгож ажиллах

3.1.2 Албан томилолттой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд албан томилолтоор ажилласан хүмүүст унаа хоолны мөнгө давхцуулан олгосон зөрчил илэрсэн нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр унааны зардал, байрны зардал, хоолны зардал зардлаас бүрдэнэ, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.2-т " Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам, түүний хэмжээг Засгийн газар тогтооно", гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчдыг албан томилолтоор ажиллах үед унаа, хоолны зардлын хөнгөлөлтийн тооцооллыг зөв хийж, илүү олгогдсон томилолтын зардлыг тухай бүрд нь суутган тооцож ажиллах

3.1.3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Төрийн албаны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын холбогдох тогтоолд заасан шаардлагын дагуу ТЗ-ын албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн гэрээг дүгнэж ажилласан боловч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нийт албан тушаалтнуудын ажлын үр дүнгийн гэрээг дүгнээгүй байгаа нь "Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.1 Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно, Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна, Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албан хаагчдаас гадна хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны улирлын ажлын гэрээг дүгнэн хуульд заасан нэмэгдлийг олгож ажиллах

3.1.4 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Нийт албан хаагчдад бөмбөр куртик, футболк худалдан авсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д

“Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

3.1.5 Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн 2025 оны 7-12 дугаар саруудын тайланд цалингийн санг зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;”, 32.2.3-т “нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;”, 32.2.-т нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын газарт хүсэлт уламжилж 2025 оны 7-12 саруудын тайланг засварлан ажиллах

3.1.6 Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмч эзэмшүүлэх гэрээг байгуулаагүй, түрээсийн төлбөрийн 40 хувийг журамд заасны дагуу төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 49,50 дугаар тогтоолуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч эзэмшүүлэх гэрээ байгуулан, түрээсийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэн ажиллаж хэвших.

3.1.7 Байгууллагын 100 жилийн ойн үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивын мөнгөн хөрөнгийг хувь хүний харилцах дансанд төвлөрүүлэн, нийт дүнгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж

3.1.8 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын албан хаагчидтай холбоотой авлага барагдуулах ажил зохион байгуулан ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг

зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх", гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан хаагчидтай холбоотой авлагыг 2026 оны эхний хагас жилд багтаан суутган тооцох,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
ХГБХХгазар	Санхүүгийн үр дүнгийн тайлан, цалингийн зардал зөрүүтэй хүлээн зөвшөөрсөн	1	4,202.1	0	0	1	4,202.1	1	4,202.1	0	0	0	0
	Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлд зөрүүтэй тусгасан	1	25,992.1			1	25,992.1	1	25,992.1				
	Дугуйлангийн орлого хандивын орлого, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогуудыг мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайлангуудад зөрүүтэй бүртгэсэн	1	3,637.4			1	3,637.4	1	3,637.4				
	Тайлант үеийн үр дүнгийн зардал зөрүүтэй хүлээн зөвшөөрсөн	1	9,186.2			1	9,186.2	1	9,186.2				
	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй	1	4,290.0			1	4,290.0	1	4,290.0				
	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэг шилжүүлгийн мөнгөн хөрөнгийг зөрүүтэй илэрхийлсэн	1	106,931.1			1	106,931.1		1				

Нийт дүн	6	154,239.1	0	6	154,239.1	6	154,239.1	0	0	0	0
----------	---	-----------	---	---	-----------	---	-----------	---	---	---	---

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Тайлант онд үр дүнгийн урамшуулалт цалин Засгийн газрын тогтоолоос зөрүүтэй цалин олгосон	1	3,073.50	1	3,073.50							-	-	-	-
МУЗГ-ын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан журмыг хэрэгжүүлэн ажиллагаагүй; Ээлжийн ажилтай жижүүр багш нарын цагийн тооцоог нарийлан бүртгээгүй байна, илүү цагийг хөдөлмөрийн хуульд заасны дагуу бүртгэл хөтлөн баталгаажуулаагүй	1	57,057					1	57,057						
Албан томилолтын тооцоог бодож олгохдоо унаа хоолны хөнгөлөлт; байрны зардал; хоолны зардлын тооцоо хийж ажиллаагүй	1	32,918.00					1	32,918.00						
Тус байгууллага нь Төрийн албаны тухай хууль болон Монгол улсын Засгийн газрын тогтоолд заасны дагуу ТЗ-ны албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн гэрээг дүгнэн ажиллаж байгаа хэдий ч хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа нийт албан тушаалтнуудын гэрээг дүгнэж мөнгөн урамшуулал олгоогүй	1						1						-	-

7-12 дугаар саруудын НДШ тайланг илүү дутуу	1						1					
Байгууллагын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандивын мөнгөн хөрөнгийг төрийн бус байгууллагын холбогдох дансанд төвлөрүүлэн, нийт дүнгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн	1	37,041.00					1	37,041.00				
Өмч эзэмшүүлэх гэрээ хийгээгүй, түрээсийн төлбөрийн 40 хувийг журамд заасны дагуу төвлөрүүлэн ажиллаагүй өмч эзэмшүүлэх гэрээ хийгээгүй байна	1						1					
Насжилт өндөртэй авлага барагдуулах ажил зохин байгуулан ажиллаагүй	1	4,472.9					1	4,472.9				
Дүн	8	134,562.4	1.00	3,073.50	0.00	0.00	7.00	131,488.9				

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
ХГБХХгазар	Төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авсан	1	5,356.5					1	5,356.5
Нийт дүн		1	5,356.5					1	5,356.5

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ал	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		